



# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

### НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД: ЭУГ-2025/21-ШТА-НА

2025 он



# “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүнд хийсэн нийцлийн аудитад түүврийн аргаар 51 байгууллага хамрагдсан ба уг аудитаар нийтдээ 508.9 сая төгрөгийг зөрчил илэрч 3 байгууллагад 5.1 сая төгрөгийн нөхөн төлүүлэх акт тогтоож, 16 байгууллагад 503.8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгөв.

Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй 4 байгууллагад 21.5 сая төгрөгийн

Тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй 2 байгууллагад 1.3 сая төгрөгийн

Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй 1 байгууллагад 5.0 сая төгрөгийн

Бусад хангамжийн зардлыг хэмнэж ажиллаагүй 1 байгууллагад 13.7 сая төгрөгийн

Цахим худалдан авалтыг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлээгүй 11 байгууллагад 399.3 сая төгрөгийн

Хэмнэлтийн бусад арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулаагүй 6 байгууллагад 68.2 сая төгрөгийн зөрчлүүд байна

Тус аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж шалгасан бөгөөд 2022 онд 709.5 сая төгрөгийн, 2023 онд 161.8 сая төгрөгийн, 2024 онд 400.1 сая төгрөгийн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийгдсэн нийцлийн аудитаар 508.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна



# “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2022-2024 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудит болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 192 байгууллагаас нийтдээ 39,401.6 сая төгрөгийн зөрчил илэрч 90 байгууллагад 22,412.6 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 97 байгууллагад 13,192.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, 5 байгууллагад 3,796.7 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 8 байгууллагад 2,409.0 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна

## Зөвлөмж

### I. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албад:

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж, дотоод хяналтыг тогтмолжуулж, үр

### II. Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

Төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг цахим худалдан авалт, худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх талаар сургалт, арга зүйгээр хангаж ажиллах;

